



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062

Цахим хаяг: ikhnyadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ М.БОРХҮҮХЭН ТАНАА

2024-02-26 № 43

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, хувийн байгууллагаас 10.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөд үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын бичиг баримт болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 88.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,787,144.66	183,157,617.69
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	8,813,693.25	91,617,186.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,813,693.25	91,617,186.28
3121	Төгрөг	8,813,693.25	91,617,186.28
31211	Төрийн сангийн харилцах	2,651,342.30	80,872,848.72
31218	Ахмадын сангийн харилцах	6,162,350.95	10,744,337.56
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	-	-
33	АВЛАГА	7,266,439.00	3,906,439.00
33500	Бусад авлага	7,266,439.00	3,906,439.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,266,439.00	3,906,439.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,707,012.41	87,633,992.41
35100	Түүхий эд материал	37,141,632.41	44,490,442.41
35110	Тусгай зориулалттай материал	37,141,632.41	44,407,142.41
35130	Эм боох материал	0.00	83,300.00
35400	Хангамжийн материал	36,565,380.00	43,143,550.00
35410	Бичиг хэргийн материал	1,485,600.00	3,505,500.00
35420	Аж ахуйн материал	27,642,350.00	30,954,240.00
35450	Барилгын засварын материал	0.00	1,223,800.00
35460	Хүнсний материал	7,437,430.00	7,460,010.00
35470	Бусад хангамжийн материал		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,740,539,724.93	1,671,967,079.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,740,539,724.93	1,671,967,079.79
392	Биет хөрөнгө	1,708,283,724.93	1,639,711,079.79
39201	Барилга, байгууламж	1,673,723,054.00	1,673,723,054.00
39202	Хуримтлагдсан элэгдэл- барилга	(67,616,952.70)	(115,200,873.46)
39205	Машин, тоног төхөөрөмж	79,418,452.70	78,647,161.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,701,623.47)	(26,890,600.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,211,188.00	57,061,188.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,750,393.60)	(27,628,850.22)
393	Биет бус хөрөнгө	32,256,000.00	32,256,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,256,000.00	32,256,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,830,326,869.59	1,855,124,697.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,119,113.39	8,713,395.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,119,113.39	8,713,395.00
41300	Өглөг	5,119,113.39	8,713,395.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,119,113.39	0.00
41312	НДШ-ийн өглөг	5,119,113.39	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	8,713,395.00
413203	Түлш халаалтын өглөг	0.00	8,713,395.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,825,207,756.20	1,846,411,302.48
51	Засгийн газрын хувь оролцоо	1,825,207,756.20	1,846,411,302.48
51101	Өмч: -Төрийн өмч	157,413,081.98	157,413,081.98
512	Хуримтлагдсан үр дүн	1,665,365,494.92	1,686,569,041.20
51210	Өмнөх үеийн үр дүн	(139,655,322.28)	(1,670,484,608.31)
51220	Тайлант үеийн үр дүн	1,805,020,817.20	16,084,432.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,429,179.30	2,429,179.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,830,326,869.59	1,855,124,697.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,375,601,897.14	697,959,577.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,872,096,797.14	34,088,977.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,872,096,797.14	34,088,977.60
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,302,350.95	11,573,867.60
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,302,350.95	11,573,867.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	1,791,764,180.47	12,025,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	74,030,265.72	10,490,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	503,505,100.00	663,870,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	423,000,700.00	595,808,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	423,000,700.00	595,808,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	103,500.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,400,900.00	68,062,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,400,900.00	68,062,300.00
1330	Төсвийн захирагчдаас		
133003	Хөрөнгийн		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	568,565,635.13	680,352,061.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,565,635.13	680,352,061.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,609,611.11	680,253,185.76
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	316,825,667.00	391,337,256.18
210101	Цалин	237,487,883.00	309,183,924.04
210102	Нэмэгдэл цалин	54,567,895.00	66,132,611.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,288,730.00	2,811,000.00
210104	Урамшуулал	22,481,159.00	13,209,721.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,701,482.09	47,626,650.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,223,324.93	32,755,937.10
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,205,061.17	3,825,407.45
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,496,668.79	3,025,797.68
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	609,940.42	716,951.07
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,166,486.78	7,302,556.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,188,546.98	73,576,819.74
210301	Гэрэл, цахилгаан	4,981,052.98	6,333,834.13
210302	Түлш, Халаалт	48,407,744.00	57,121,139.00
210303	Цэвэр, бохир ус	5,799,750.00	10,121,846.61
2104	Хангамж, бараа материалын зардал	14,017,165.31	3,594,420.00
210401	Бичиг хэрэг	2,289,953.03	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,496,063.00	3,594,420.00
210408	Бараа материал актласны зардал	1,231,149.28	0.00
2105	Нормативт зардал	45,121,949.00	63,683,215.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	181,970.00	42,800.00
210502	Хоол, хүнс	44,939,979.00	63,640,415.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,825,310.00	1,577,200.00
210604	Урсгал засвар	3,825,310.00	1,577,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	894,000.00	1,219,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	894,000.00	1,219,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,035,490.73	97,637,724.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,699,500.00	12,860,113.39
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,837,820.00	1,912,150.00

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,498,170.73	82,865,461.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,956,024.02	98,875.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,827,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	11,827,700.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,128,324.02	98,875.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,128,324.02	98,875.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	1,807,036,262.01	17,607,516.58
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,015,444.81	1,523,083.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	2,015,444.81	1,523,083.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,015,444.81	1,523,083.69
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=IV-V)	1,805,020,817.20	16,084,432.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	509,807,450.95	678,804,467.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,302,350.95	14,933,867.60
120	Нийтлэг татварын бус орлого	6,302,350.95	14,933,867.60
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,302,350.95	14,933,867.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	140,000.00	4,329,867.60
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	6,162,350.95	10,604,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	503,505,100.00	663,870,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	423,000,700.00	595,808,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	423,000,700.00	595,808,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	103,500.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,400,900.00	68,062,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,400,900.00	68,062,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	494,625,097.70	592,210,074.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,625,097.70	592,210,074.57
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,669,073.68	592,111,199.31
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	311,706,553.61	391,337,256.18
210101	Үндсэн цалин	232,368,769.61	309,183,924.04
210102	Нэмэгдэл	54,567,895.00	66,132,611.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,288,730.00	2,811,000.00
210104	Урамшуулал	22,481,159.00	13,209,721.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,701,482.09	47,626,650.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,223,324.93	32,755,937.10
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,205,061.17	3,825,407.45
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,496,668.79	3,025,797.68
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	609,940.42	716,951.07
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,166,486.76	7,302,556.70
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	59,188,546.98	64,863,424.74
210301	Гэрэл, цахилгаан	4,981,052.98	6,860,600.74
210302	Түлш, халаалт	48,407,744.00	48,407,744.00
210303	Цэвэр, бохир ус	5,799,750.00	9,595,080.00
2105	Нормативт зардал	49,010,210.00	63,662,995.00
210502	Хоол, хүнс	49,010,210.00	63,662,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,400,000.00	3,100,000.00
210604	Урсгал засвар	3,400,000.00	3,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	894,000.00	1,219,900.00

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	894,000.00	1,219,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,768,281.00	20,300,973.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,856,041.00	16,641,273.39
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,912,240.00	3,659,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,956,024.02	98,875.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,827,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	11,827,700.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,128,324.02	98,875.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,128,324.02	98,875.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,182,353.25	86,594,393.03
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,368,660.00	3,790,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,368,660.00	3,790,900.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	6,368,660.00	3,790,900.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	6,368,660.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,368,660.00	3,790,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,368,660.00)	(3,790,900.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,813,693.25	82,803,493.03
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,813,693.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,651,342.30	91,617,186.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	1,673,588,698.21	1,833,430,959.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,813,244,020.49)	(1,813,244,020.49)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	(139,655,322.28)	20,186,939.00
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	1,805,20,817.20	1,805,020,817.20
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	1,665,365,494.92	1,825,207,756.20
D01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	1,665,365,494.92	1,825,207,756.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,119,113.39	5,119,113.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	1,670,484,608.31	1,830,326,869.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	16,084,432.89	16,084,432.89
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	157,413,081.98	2,429,179.30	1,686,569,041.20	1,846,411,302.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,651,342.30
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	666,521,800.00	589,880,085.92
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	666,521,800.00	589,880,085.92
210	Бараа, үйлчилгээний зардал	666,521,800.00	589,880,085.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,384,600.00	391,337,256.18
210101	Үндсэн цалин	302,389,000.00	309,183,924.04
210102	Нэмэгдэл	136,380,800.00	66,132,611.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	-	2,811,000.00
210104	Урамшуулал	13,614,800.00	13,209,721.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,548,400.00	47,626,650.00
210201	Тэтгэврийн даатгал	38,452,600.00	32,755,937.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,524,100.00	3,825,407.45
210203	ҮОМШӨ ний даатгал	3,619,200.00	3,025,797.68
210204	Ажилгүйдлийн даатгал	904,800.00	716,951.07
210205	Эрүүл мэндийн даатгал	9,047,700.00	7,302,556.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,962,300.00	64,863,424.74
210301	Гэрэл, цахилгаан	6,860,700.00	6,860,600.74
210302	Түлш, халаалт	48,408,400.00	48,407,744.00
210303	Цэвэр, бохир ус	9,693,200.00	9,595,080.00
2105	Нормативт зардал	70,000,700.00	63,662,995.00
210502	Хоол хүнс	70,000,700.00	63,662,995.00
2106	Эд хогшил худалдан авах	3,100,000.00	3,100,000.00
210604	Урсгал засвар	3,100,000.00	3,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,219,900.00	1,219,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,219,900.00	1,219,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,305,900.00	18,069,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,646,200.00	14,410,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,659,700.00	3,659,700.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,651,200.00	
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	2,651,200.00	
300001	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,651,200.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	663,870,600.00	668,200,467.60
12200	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	4,329,867.60
122005	Төсвөөс санхүүжих	663,870,600.00	663,870,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,651,342.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		80,872,848.72
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	7	7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,664.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 6,493.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1 зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж, 25.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 145.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 170.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 6,803.5 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалаас авах листний мөнгийг үр дүнгийн тайланд орлогоор тусгасан	1	1,317.4			1	1,317.4	1	1,317.4				
Цалингийн хүснэгтээрх тооцсон цалинг ерөнхий журналд илүү тусгасан	1	5,176.6			1	5,176.6	1	5,176.6				
Дүн	2	6,493.9			2	6,493.9	2	6,493.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолттой 1 албан хаагчид хоолны мөнгийг давхардуулан олгосон	1	25.0	1	25.0								
Дүн	1	25.0	1	25.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансанд 33,808.2 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ мэдээлээгүй. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжүүлээгүй.	1	-			1	-		
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	145.5					1	145.5
Дүн	2	145.5			1	-	1	145.5
Нийт дүн	2	145.5			1	-	1	145.5

5. ТӨСӨВ ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 165

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар шилэн дансанд 33,808,234.00 /гучин гурван сая найман зуун найман мянга хоёр зуун гучин дөрөв/ төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (М.Борхүүхэн), нягтлан бодогч (Н.Саранзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР /М.МӨНХЗУЛ/

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Р.МӨНХТОГТОХ/



¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 55

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар албан томилолттой албан хаагчид 25,000 төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 20.2.3-д /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/, Монгол улсын Сангийн сайдын 2020 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаалын 1-д /*Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг,....., байрны зардлыг 40,000 төгрөг тус тус шинэчлэн баталсугай*./ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно./, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3 -т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчид илүү олгосон албан томилолтын 25,000 /Хорин таван мянган/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх;

Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч М.Борхүүхэн, Нягтлан бодогч Н.Саранзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

М.МӨНХЗУЛ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0020240095